



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/183/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: Audit.mn Хэнтий аймаг Чингис хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 мэйл хаяг: Khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 мэйл хаяг: Oyuntuyad@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Энх-Амгалан Утас: 91119424 мэйл хаяг: Enkh-Amgalang@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	4
Аудитын гол асуудал	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	12
3.1 Төлбөрийн акт	12
3.2 Албан шаардлага	12
4.3 Зөвлөмж	15
5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.25

№

435

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

- ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нь өөртөө шийдвэр гаргаж 2,066.6 мянган төгрөгийн илүү цагийн хөлс авсан;
- Нэр бүхий ажилтнуудад Хөдөлмөрийн тухай хуульд заасан үндэслэлд хамаарахгүй нөхцөлөөр 18,696.6 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг олгосон;
- Байгууллагын дансанд бүртгэлтэй 6,521.7 мянган төгрөгийн малыг тоолж, тооцоо бодож баталгаажуулаагүй;
- Цогт-Өндөр багийн 6 цэцэрлэгт 17,869.9 мянган төгрөгийн халаалтын тогоо солих төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж 2025 оны 5-р сард ЗДТГ хүлээн авсан боловч халаалтын тогоо цоорч ашиглах боломжгүй болсонтой холбоотойгоор нийлүүлэгчийн баталгаат хугацаанд хариуцах үүргийг нэхэмжлэлгүйгээр шинэ халаалтын тогоо нэмж худалдан авсан;
- ЗДТГ-ын газарт бүртгэлтэй хөрөнгийг түрээсэлж гэрээний дагуу төлбөрөө төлөөгүй 38 иргэний 27,426.8 мянган төгрөгийн авлагыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2 “төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 26.1-т “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1. “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 4-т “Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачлагчаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно” гэснийг зөрчсөн нь санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, толилуулга, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас 453,580.8 мянган төгрөгийн трактор, тоног төхөөрөмж, аймгийн хөрөнгө оруулалт, аймаг, сумын ОНХС-ийн сангийн хөрөнгөөр 668,337.5 мянган төгрөгийн их засвар, барилга байгууламжийг үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгажээ.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар 4,067,845.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 2,065.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 4,065,779.1 мянган төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага, хөрөнгийн ашиглалт, бүртгэлтэй холбоотой зөрчилд 1 зөвлөмж хүргүүлжээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Цалингийн payroll программаас цалингийн бичилтийг татаж нягтлан бодох бүртгэлд мөнгөн сууриар бүртгэсэн нь нийгмийн даатгал, татвар болон ажиллагсадтай холбоотой тооцоололд тавих хяналт хангалтгүй байгааг анхаарах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	256,427,927.40	317,832,736.88
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,000.00	92,600.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	7,000.00	92,600.00
3121	Төгрөг	7,000.00	92,600.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	7,000.00	92,600.00
33	АВЛАГА	22,929,777.58	9,888,661.06
335	Бусад авлага	22,929,777.58	9,888,661.06
3351	Байгууллагаас авах авлага	22,929,777.58	9,888,661.06
34	УРЬДЧИЛГАА	180,000.00	180,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	180,000.00	180,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	180,000.00	180,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	201,811,149.82	259,871,475.82
351	Түүхий эд материал	41,870,861.82	24,373,651.82
35110	Тусгай зориулалттай материал	35,774,851.82	24,373,651.82
35130	Эм боох материал	6,096,010.00	-
354	Хангамжийн материал	153,418,558.00	228,976,094.00
35410	Бичиг хэргийн материал	6,770,124.00	4,533,625.00
35420	Аж ахуйн материал	128,934,184.00	177,039,569.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,374,500.00	2,607,000.00
35440	Түлц, шатах тослох материал	3,600,000.00	10,053,500.00
35450	Барилгын засварын материал	12,139,750.00	4,132,300.00
35470	Бусад хангамжийн материал	600,000.00	30,610,100.00
35600	Мал амьтад	6,521,730.00	6,521,730.00
36	НӨӨЦИЙН БАРАА	31,500,000.00	47,800,000.00
36300	Гэжээлийн нөөц	24,500,000.00	47,800,000.00
36400	Шатахууны нөөц	7,000,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,800,124,295.06	9,996,894,888.31
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,800,124,295.06	9,996,894,888.31
392	Биет хөрөнгө	3,458,887,637.06	4,655,658,230.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,416,137,206.37	4,313,603,504.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	(469,653,665.94)	(592,593,419.04)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	246,490,000.00	344,823,333.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(87,789,999.84)	(120,676,110.85)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	337,998,397.90	761,255,940.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(133,454,816.51)	(196,207,177.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	129,520,231.00	158,664,231.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(66,076,952.24)	(84,153,712.01)
39214	Бусад үндсэн хөрөнгө	151,127,220.00	168,997,211.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(65,409,983.68)	(98,055,570.70)
393	Биет бус хөрөнгө	5,341,236,658.00	5,341,236,658.00
39301	Програм хангамж	1,810,000.00	630,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,810,000.00)	(630,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,341,236,658.00	5,341,236,658.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,056,552,222.46	10,314,727,625.19
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	68,926,191.06
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	68,926,191.06
413	Өглөг	-	68,926,191.06
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	15,367,447.06
4136	Бусад өглөг	-	53,558,744.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	35,549,009.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	18,009,735.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,056,552,222.46	10,245,801,434.13
51	Засгийн газрын хувь оролцоо	9,056,552,222.46	10,245,801,434.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,234,447,071.90	1,234,447,071.90
51101	Өмч: - төрийн	1,234,447,071.90	1,234,447,071.90
512	Хуримтлагдсан үр дүн	6,833,981,585.56	8,023,230,797.23
51210	Өмнөх үеийн үр дүн	6,833,981,585.56	6,833,981,585.56
51220	Тайланг үеийн үр дүн	-	1,189,249,211.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	988,123,565.00	988,123,565.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,056,552,222.46	10,314,727,625.19

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,444,925,419.04	4,807,788,293.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,584,768,754.04	1,224,856,884.76
120	Нийтлэг татварын бус орлого	4,584,768,754.04	1,224,856,884.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,584,768,754.04	1,224,856,884.76
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,819,200.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,582,949,554.04	1,224,856,884.76
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,860,156,665.00	3,582,931,409.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	83,589,665.00	39,537,609.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,011,345.00	12,243,127.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	79,578,320.00	27,294,482.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,776,567,000.00	3,543,393,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,776,567,000.00	3,543,393,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,950,306,636.13	3,618,539,082.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,996,168,414.52	3,311,505,840.09
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,456,909,735.21	2,823,985,840.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,247,008,617.23	1,526,153,251.10
210101	Үндсэн цалин	685,917,428.93	693,716,721.80
210102	Нэмэгдэл	369,887,002.13	448,061,068.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	94,579,289.35	128,345,600.04
210104	Урамшуулал	42,224,361.67	49,539,029.11
210105	Гэрээт ажлын хөлс	54,400,535.15	206,490,831.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	155,717,244.62	190,641,309.72
210201	Тэтгэврийн даатгал	105,745,215.05	130,092,226.77
210202	Тэтгэмжийн даатгал	12,666,506.90	15,315,300.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,344,484.94	8,058,628.09
210204	Ажилгүйдлийн даатгал	6,106,007.12	7,435,190.92
210205	Эрүүл мэндийн даатгал	24,855,030.61	29,739,963.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	200,032,287.49	216,276,416.31
210301	Гэрэл, цахилгаан	33,242,708.19	47,990,482.51
210302	Түлш, халаалт	157,644,701.30	157,017,320.80
210303	Цэвэр, бохир ус	9,144,878.00	11,268,613.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,319,770.00	165,123,530.00
210401	Бичиг хэрэг	9,388,400.00	18,076,480.00
210402	Тээвэр, шатахуун	24,996,390.00	62,407,942.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,765,180.00	12,095,622.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	540,000.00	540,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,629,800.00	14,252,900.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	619,550.00
210408	Бараа материал акталсны зардал	-	57,131,036.00
2105	Нормативт зардал	3,237,100.00	482,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,237,100.00	482,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	92,760,420.00	68,627,015.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	8,110,500.00
210604	Урсгал засвар	86,760,420.00	60,516,515.00
2107	Томиллолт, зочны зардал	8,288,000.00	15,680,000.00
210702	Дотоод албан томиллолт	8,288,000.00	15,680,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	244,074,416.00	223,920,663.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	220,316,436.00	219,432,799.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,900,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	534,180.00	1,239,101.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	67,000.00	79,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,025,000.00	1,585,000.00
210807	Газрын төлбөр	15,231,800.00	1,584,263.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	459,471,879.87	417,081,055.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	247,277,117.00	128,921,484.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,040,400.00	2,937,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	210,154,362.87	285,222,571.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	539,258,679.31	487,519,999.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	102,506,790.17	22,667,754.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,140,937.67	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад тө	43,565,872.50	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,799,980.00	22,667,754.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжил	436,751,889.14	464,852,245.45
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	436,751,889.14	464,852,245.45
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	954,138,221.61	307,033,242.00
2200	Дотоод эх үүсвэрээр	954,138,221.61	307,033,242.00
223001	Бусад хөрөнгө	954,138,221.61	307,033,242.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	4,494,618,782.91	1,189,249,211.67
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	4,494,618,782.91	1,189,249,211.67

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,912,631,710.84	3,613,861,186.58
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,819,200.00	8,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,819,200.00	8,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,819,200.00	8,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,819,200.00	8,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,902,812,510.84	3,605,861,186.58
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	126,245,510.84	62,467,386.58
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс до	4,011,345.00	12,243,127.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий бо	122,234,165.84	50,224,259.58
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,776,567,000.00	3,543,393,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байг	3,776,567,000.00	3,543,393,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,853,772,861.65	3,070,466,513.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,853,772,861.65	3,070,466,513.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,315,604,432.34	2,572,660,850.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,247,008,617.23	1,513,243,509.04
210101	Үндсэн цалин	685,917,428.93	680,806,979.74
210102	Нэмэгдэл	369,887,002.13	448,061,068.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	94,579,289.35	128,345,600.04
210104	Урамшуулал	42,224,361.67	49,539,029.11
210105	Гэрээт ажлын хөлс	54,400,535.15	206,490,831.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	155,717,244.62	190,641,309.72
210201	Тэтгэврийн даатгал	105,745,215.05	130,092,226.77
210202	Тэтгэмжийн даатгал	12,666,506.90	15,315,300.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,344,484.94	8,058,628.09
210204	Ажилгүйдлийн даатгал	6,106,007.12	7,435,190.92
210205	Эрүүл мэндийн даатгал	24,855,030.61	29,739,963.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	203,632,287.49	224,329,916.31
210301	Гэрэл, цахилгаан	33,242,708.19	47,990,482.51
210302	Түлш, халаалт	161,244,701.30	165,070,820.80
210303	Цэвэр, бохир ус	9,144,878.00	11,268,613.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,007,470.00	76,204,993.00
210401	Бичиг хэрэг	9,614,300.00	9,346,300.00
210402	Тээвэр, шатахуун	24,996,390.00	37,506,926.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,765,180.00	12,095,622.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	540,000.00	540,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,091,600.00	16,716,145.00
2105	Нормативт зардал	3,934,600.00	4,279,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,934,600.00	4,279,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	102,743,230.00	86,968,730.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,040,660.00	20,852,670.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	620,000.00	-
210604	Урсгал засвар	96,082,570.00	66,116,060.00
2107	Томилолт, зочны зардал	8,288,000.00	15,680,000.00
210702	Дотоод албан томилолт	8,288,000.00	15,680,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	266,783,216.00	227,269,188.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний тө	242,475,236.00	222,781,324.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,900,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	534,180.00	1,239,101.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	67,000.00	79,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,575,000.00	1,585,000.00
210807	Газрын төлбөр	15,231,800.00	1,584,263.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	280,489,767.00	234,044,004.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	277,974,767.00	231,319,004.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,515,000.00	2,725,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	538,168,429.31	497,805,663.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	101,416,540.17	23,064,757.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,140,937.67	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаа	43,565,872.50	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	41,709,730.00	23,064,757.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, са	436,751,889.14	474,740,906.51
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	436,751,889.14	464,852,245.45
213404	Нэмэлт данснаас төвлөрүүлэх шилжүүлэг	-	9,888,661.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,058,858,849.19	543,394,673.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,035,929,071.61	543,309,073.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,035,929,071.61	543,309,073.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,035,929,071.61	543,309,073.00
222001	Тоног төхөөрөмж	81,790,850.00	114,901,577.00
223001	Бусад хөрөнгө	954,138,221.61	428,407,496.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	(1,035,929,071.61)	(543,309,073.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	22,929,777.58	85,600.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	7,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,000.00	92,600.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,234,447,071.90	988,123,565.00	2,335,631,221.66	4,558,201,858.56
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	714,845.07	714,845.07
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,234,447,071.90	988,123,565.00	2,336,346,066.73	4,558,916,703.63
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	4,497,635,518.83	4,497,635,518.83
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,234,447,071.90	988,123,565.00	6,833,981,585.56	9,056,552,222.46
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,234,447,071.90	988,123,565.00	6,833,981,585.56	9,056,552,222.46
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,234,447,071.90	988,123,565.00	6,833,981,585.56	9,056,552,222.46
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	1,189,249,211.67	1,189,249,211.67
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,234,447,071.90	988,123,565.00	8,023,230,797.23	10,245,801,434.13

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-
2	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,543,393,800.00	3,078,541,554.55	464,852,245.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,890,393,800.00	2,650,134,058.55	240,259,741.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,865,393,800.00	2,627,945,451.55	237,448,348.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,580,564,300.00	1,513,015,509.04	67,548,790.96
210101	Үндсэн цалин	800,604,400.00	680,578,979.74	120,025,420.26
210102	Нэмэгдэл	236,861,700.00	448,061,068.20	-211,199,368.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	132,000,000.00	128,345,600.04	3,654,399.96
210104	Урамшуулал	115,000,000.00	49,539,029.11	65,460,970.89
210105	Гэрээт ажлын хөлс	296,098,200.00	206,490,831.95	89,607,368.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шилжүүлэг	197,064,400.00	190,641,309.72	6,423,090.28
210201	Тэтгэврийн даатгал	133,841,700.00	130,092,226.77	3,749,473.23
210202	Тэтгэмжийн даатгал	15,805,800.00	15,315,300.33	490,499.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,902,800.00	8,058,628.09	(155,828.09)
210204	Ажилгүйдлийн даатгал	7,902,800.00	7,435,190.92	467,609.08
210205	Эрүүл мэндийн даатгал	31,611,300.00	29,739,963.61	1,871,336.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	247,291,800.00	222,226,691.37	25,065,108.63
210301	Гэрэл, цахилгаан	59,301,000.00	46,812,257.57	12,488,742.43
210302	Түлш, халаалт	173,824,800.00	164,145,820.80	9,678,979.20
210303	Цэвэр, бохир ус	14,166,000.00	11,268,613.00	2,897,387.00
2104	Хангамж, бараа материалын зардал	74,064,000.00	60,046,573.00	14,017,427.00
210401	Бичиг хэрэг	13,016,700.00	9,346,300.00	3,670,400.00
210402	Тээвэр, шатахуун	45,000,400.00	35,506,926.00	9,493,474.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,000,000.00	9,268,447.00	731,553.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн ус	1,046,500.00	540,000.00	506,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,400.00	5,384,900.00	(384,500.00)
2105	Нормативт зардал	7,000,000.00	4,279,200.00	2,720,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,000,000.00	4,279,200.00	2,720,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	143,735,600.00	110,219,669.42	33,515,930.58
210601	Багаж, техник, хэрэгсэл	65,000,000.00	58,076,469.42	6,923,530.58
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	943,100.00	00.00	943,100.00
210604	Урсгал засвар	77,792,500.00	52,143,200.00	25,649,300.00
2107	Томилолт, зочны зардал	18,540,000.00	15,680,000.00	2,860,000.00
210702	Дотоод албан томилолт	18,540,000.00	15,680,000.00	2,860,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний тусламж	297,034,100.00	261,606,047.00	35,428,053.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	279,264,300.00	257,118,183.00	22,146,117.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	624,200.00	00.00	624,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,500,000.00	-	2,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,145,600.00	1,239,101.00	906,499.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	500,000.00	79,500.00	420,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000,000.00	1,585,000.00	415,000.00
210807	Газрын төлбөр	10,000,000.00	1,584,263.00	8,415,737.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	300,099,600.00	250,230,452.00	49,869,148.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	295,549,800.00	247,505,452.00	48,044,348.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,549,800.00	2,725,000.00	1,824,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,000,000.00	22,188,607.00	2,811,393.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,000,000.00	22,188,607.00	2,811,393.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,000,000.00	22,188,607.00	2,811,393.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	653,000,000.00	428,407,496.00	224,592,504.00
2200	Дотоод эх үүсвэрээр	653,000,000.00	428,407,496.00	224,592,504.00
223001	Бусад хөрөнгө	653,000,000.00	428,407,496.00	224,592,504.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,543,393,800.00	3,078,541,554.55	464,852,245.45
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,543,393,800.00	3,070,541,554.55	472,852,245.45
132001	Орон нутгийн төсвөөс	3,543,393,800.00	3,070,541,554.55	472,852,245.45
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	8,000,000.00	-8,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	8,000,000.00	-8,000,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	62,467,386.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	53,477,609.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42,712,797.94
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,103,224.94
210301	Гэрэл, цахилгаан	1,178,224.94
210302	Түлш, халаалт	925,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,158,420.00
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,827,175.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,331,245.00
2105	Нормативт зардал	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,646,860.00
210604	Урсгал засвар	15,646,860.00
2107	Томилолт, зочны зардал	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,363,141.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,363,141.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,441,152.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,441,152.00
211	ХҮҮ	-
212	ТАТААС	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	876,150.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	876,150.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	876,150.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,888,661.06
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	9,888,661.06
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,989,777.58
2200	Дотоод эх үүсвэрээр	8,989,777.58
222001	Тоног төхөөрөмж	8,989,777.58
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	62,467,386.58
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	62,467,386.58
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,243,127.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	50,224,259.58
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд алдаа¹ илрээгүй.

Тайлант онд аудитаар нийт 4,067,845.7 мянган төгрөгийн зөрчил илэрч, 2,066.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 4,065,779.1 мянган төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага хүргүүлж, үндсэн хөрөнгийн бүртгэл, ашиглалттай холбоотой зөрчилд 1 зөвлөмж хүргүүллээ.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар илэрсэн зөрчилд дараах төлбөрийн актыг тогтоолоо. Үүнд:

- ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нь өөртөө шийдвэр гаргаж 2,066,586.00 (Хоёр сая жаран зургаан мянга таван зуун наян зургаан) төгрөгийн илүү цагийн хөлс авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1. “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасныг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Аудитаар илэрсэн зөрчилд дараах албан шаардлагыг хүргүүлж байна. Үүнд:

- Шатах тослох материалын тайланг гаргаагүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт болон хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2. “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”, Сангийн сайдын 2000 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 2.10 “Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид гаргаж өгнө” гэж заасныг тус тус зөрчиж “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүллээ.

- Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэргүйгээр ЗДТГ-ын даргын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/41 тушаалаар 55,767.5 мянган төгрөгийн бараа материалыг акталж данс бүртгэлээс хассан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2. “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Төрийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1/“худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах байнгын зөвлөл дүгнэлт гарсан байх” гэж заасныг зөрчиж “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлээ.

- Нэр бүхий ажилтнуудад Хөдөлмөрийн тухай хуульд заасан үндэслэлд хамаарахгүй нөхцөлөөр 18,696.6 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 4-т “Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачлагчаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно” гэсэн заалтыг тус тус зөрчиж “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлээ.

- Байгууллагын дансанд бүртгэлтэй 6,521.7 мянган төгрөгийн малыг тоолж, тооцоо бодож баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12 дугаар зүйлийн 12.2 дах заалт “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ.”, 12.2.1 “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” заалт, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчиж “Оршин байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлээ.

- Цогт-Өндөр багийн 6 цэцэрлэгт 17,869.9 мянган төгрөгийн халаалтын тогоо солих төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж 2025 оны 5-р сард ЗДТГ хүлээн авсан боловч халаалтын тогоо цоорч ашиглах боломжгүй болсон байна. Үүнтэй холбоотойгоор нийлүүлэгчийн баталгаат хугацаанд хариуцах үүргийг нэхэмжлэлгүйгээр шинэ халаалтын тогоо нэмж худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2.“батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж заасныг тус тус зөрчиж “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлээ.

- Нэр бүхий 10 хүнийг Төрийн захиргааны албан тушаалд түр орлон гүйцэтгэгчээр томилохдоо төрийн үйлчилгээний цалингийн ангиллаар цалинжуулах тушаал гаргаж нэмэгдэл, урамшуулал олгосноор 25,739.0 мянган төгрөгийг илүү зарцуулсан, Төрийн албаны нөөцөд бүртгэлгүй иргэнийг төрийн захиргааны албан тушаалд түр орлон

гүйцэтгэгчээр томилж 8,515.5 мянган төгрөгийн цалин олгосон, Төрийн албаны сул орон тоо гарсан даруйд олон нийтэд мэдээлээгүй, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд захиалгыг хүргүүлээгүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.”, 42 дугаар зүйлийн 42.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол эрх бүхий этгээд дараах тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ түр орлон гүйцэтгүүлж болно”, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.3-т “Төрийн албаны тухай хуулийн 43.3.4-т заасан үндэслэлээр төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч түр орлон гүйцэтгүүлсэн бол тухайн албан тушаалын цалинг түүнд олгоно” гэсэн заалтыг тус тус зөрчиж “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлээ.

- ЗДТГ-ын газарт бүртгэлтэй хөрөнгийг түрээсэлж гэрээний дагуу төлбөрөө төлөөгүй 38 иргэний 27,426.3 мянган төгрөгийн авлагыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчиж “Толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлээ.

- ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид нэмэгдэл цалин, үр дүнгийн урамшуулалд 38,851.6 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.3-т “Төрийн албаны тухай хуулийн 43.3.4-т заасан үндэслэлээр төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч түр орлон гүйцэтгүүлсэн бол тухайн албан тушаалын цалинг түүнд олгоно”

гэж заасныг тус тус зөрчиж “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлээ.

- Нийцлийн аудитын хүрээнд илэрсэн 3,956,413.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлснийг тайлангийн 4.4.1-т тусгасан болно.

4.3 Зөвлөмж

Аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой дараах зөвлөмжийг хүргүүлээ.

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 55 нэр төрлийн 109 ширхэг хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох, акталж данс бүртгэлээс хасах эсэх саналыг бэлтгэж, шийдвэрлүүлэх.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 111,432.7 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Албан тушаалтан өөртөө шийдвэр гаргаж илүү цагийн хөлс авсан	1	2,066.6	1	2,066.6								
Үндэслэлгүй илүү цагийн хөлс олгосон	1	18,696.6			1	18,696.6						
Түр орлон гүйцэтгэгчид нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал олгосон	1	38,851.6			1	38,851.6						
БМ тайлан гаргаагүй, анхан шатны баримт хангалтгүй	1	-			1	-						
БМ-ийн тоолж баталгаажуулаагүй	1	6,521.7			1	6,521.7						
Авлагыг бүртгээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	27,426.3			1	27,426.3						
Хөрөнгөд тавин хяналт хангалтгүй	1	17,869.9			1	17,869.9						
Хууль тогтоомж зөрчиж албан хаагчдын томилгоог хийсэн	1	-			1	-						
Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэргүй БМ акталсан	1	-			1	-						
Үндсэн хөрөнгийн бүртгэл, ашиглалтай холбоотой	1	-					1	-				
Дүн	3	111,432.7	1	2,066.6	8	109,366.1	1	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулаагүй	1	3,956,413.0			1	3,956,413.0		
Дүн	1	3,956,413.0			1	3,956,413.0		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тендер зохион байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн								-
Дүн								-
Нийт дүн	1	3,956,413.0			1	3,956,413.0		-



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 173-А2360453

Чингис хот

ХЭА-2026/183/НА-СТА-ТШЗ

Г Зөрчил таслах зогсоох тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэр бүхий ажилтнуудад Хөдөлмөрийн тухай хуульд заасан үндэслэлд хамаарахгүй нөхцөлөөр 18,696,550.00 (Арван найман сая зургаан зуун ерэн зургаан мянга таван зуун тавин) төгрөгийн илүү цагийн хөлсийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 4-т "Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачлагчаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль, тогтоомжид заагдаагүй ажил үүрэгт илүү цагийн хөлсийг олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Лхагвабаатарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Г.ЭНХ-АМГАЛАН





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 142 - А2360453

Чингис хот

ХЭА-2026/183/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэргүйгээр ЗДТГ-ын даргын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/41 тушаалаар 55,767.5 мянган төгрөгийн бараа материалыг акталж данс бүртгэлээс хассан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2. "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1/"худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах байнгын зөвлөл дүгнэлт гарсан байх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1."Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэргүйгээр хөрөнгө акталдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Лхагвабаатарт даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АХЛАХ АУДИТОР

Г.ЭНХ-АМГАЛАН





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 171 - А2360453

Чингис хот

ХЭА-2026/183/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймаг Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шатах тослох материалын тайланг гаргаагүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу, хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих дотоод хяналт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2. "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", Сангийн сайдын 2000 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 2.10 "Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид гаргаж өгнө" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1. "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эд хариуцагчийн тайланг тухай бүр гаргадаггүй, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьдаггүй, баримтын бүрдүүлэлт хангалтгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Лхагвабаатарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АХЛАХ АУДИТОР

Г.ЭНХ-АМГАЛАН



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 63 - А2360453

Чингис хот

ХЭА-2026/183/НА-СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нь өөртөө шийдвэр гаргаж 2,066,586.00 (Хоёр сая жаран зургаан мянга таван зуун наян зургаан) төгрөгийн илүү цагийн хөлс авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1. "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зөрчилтэй шийдвэрээр олгосон 2,066,586.00 (Хоёр сая жаран зургаан мянга таван зуун наян зургаан) төгрөгийг ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Лхагвабаатараар төлүүлж, Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого"-ын **100180000955** дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Лхагвабаатарт хариуцуулав.


ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АХЛАХ АУДИТОР

Г.ЭНХ-АМГАЛАН





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 176 - А2360453

Чингис хот

ХЭА-2026/183/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэр бүхий 10 хүнийг Төрийн захиргааны албан тушаалд түр орлон гүйцэтгэгчээр томилон төрийн үйлчилгээний цалингийн ангиллаар цалинжуулах тушаал гаргаж 25,739.0 мянган төгрөгийг нэмэгдэл, урамшуулалд олгосон, Төрийн албаны нөөцөд бүртгэлгүй иргэнийг төрийн захиргааны албан тушаалд түр орлон гүйцэтгэгчээр томилж 8,515.5 мянган төгрөгийн цалин олгосон, Төрийн албаны сул орон тоо гарсан даруйд олон нийтэд мэдээлээгүй, Төрийн албаны зөвлөлд захиалгыг хүргүүлээгүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.", 42 дугаар зүйлийн 42.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол эрх бүхий этгээд дараах тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ түр орлон гүйцэтгүүлж болно", Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.3-т "Төрийн албаны тухай хуулийн 43.3.4-т заасан үндэслэлээр төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч түр орлон гүйцэтгүүлсэн бол тухайн албан тушаалын цалинг түүнд олгоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1. "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Түр орлон гүйцэтгэгчийг албан тушаалын бус ангиллаар цалинжуулж нэмэгдэл, урамшуулал олгодог, сул орон тооны захиалгыг хүргүүлдэггүй, нөөцөд бүртгэлгүй иргэнийг томилж ажиллуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Лхагвабаатарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Г.ЭНХ-АМГАЛАН





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 144-А2360453
ХЭА-2026/183/НА-СТА-ТШЗ

Чингис хот

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын дансанд бүртгэлтэй 6,521,730.00 (Зургаан сая таван зуун хорин нэгэн мянга долоон зуун гучин) төгрөгийн малыг тоолж, тооцоо бодож баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12 дугаар зүйлийн 12.2 дах заалт "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ.", 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" заалт, 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1."Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 4.2.1.2-т "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөрөнгийг тоолж, тооцоо бодож, баталгаажуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Лхагвабаатарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР
АХЛАХ АУДИТОР Г.ЭНХ-АМГАЛАН





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 175 - А2360453

Чингис хот

ХЭА-2026/183/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цогт-Өндөр багийн 6 цэцэрлэгт 17,869,900.00 (Арван долоон сая найман зуун жаран есөн мянга есөн зуун) төгрөгийн халаалтын тогоо солих төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж 2025 оны 5-р сард ЗДТГ хүлээн авсан боловч халаалтын тогоо цоорч ашиглах боломжгүй болсон байна. Нийлүүлэгчийн баталгаат хугацаанд хариуцах үүргийг нэхэмжлээгүй, шинэ халаалтын тогоо нэмж худалдан авч, төсвийн хөрөнгийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2. "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1. "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 4.2.1.8-т "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бэлтгэсэн хөрөнгийн баталгаат хугацааны байдалд хяналт тавьж ажиллаагүй, төсвийн хөрөнгө үнэгүйдүүлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Лхагвабаатарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Г.ЭНХ-АМГАЛАН



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 179-А2360453

Чингис хот

ХЭА-2026/183/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг байршуулах хэсэгт 391,218.2 мянган төгрөгийн 22 мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 3,554,286.0 мянган төгрөгийн 65 мэдээлэл, Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 10,908.8 мянган төгрөгийн 1, нийт 3,956,413.0 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт", 6.4.4. "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэснийг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1. "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны системд мэдээллийг ил тод мэдээлдэггүй, хяналт тавьдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Лхагвабаатар, нягтлан бодогч Г.Минжинсор-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АХЛАХ АУДИТОР

Г.ЭНХ-АМГАЛАН



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 177-А2360453

Чингис хот

ХЭА-2026/183/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид нэмэгдэл цалин, үр дүнгийн урамшуулалд 38,851,601.00 (Гучин найман сая найман зуун тавин нэгэн мянга зургаан зуун нэг) төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.3-т "Төрийн албаны тухай хуулийн 43.3.4-т заасан үндэслэлээр төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч түр орлон гүйцэтгүүлсэн бол тухайн албан тушаалын цалинг түүнд олгоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1."Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Түр орлон гүйцэтгэгчид нэмэгдэл цалин, урамшуулал олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Лхагвабаатарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АХЛАХ АУДИТОР

Г.ЭНХ-АМГАЛАН



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 178 - А2360453

Чингис хот

ХЭА-2026/183/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ЗДТГ-ын газарт бүртгэлтэй хөрөнгийг түрээсэлж гэрээний дагуу төлбөрөө төлөөгүй 38 иргэний 27,426,330.00 (Хорин долоон сая дөрвөн зуун хорин зургаан мянга гурван зуун гучин) төгрөгийн авлагыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1."Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.7-т "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагыг нягтлан бодох бүртгэлд тусгадаггүй, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Лхагвабаатарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АХЛАХ АУДИТОР

Г.ЭНХ-АМГАЛАН